

1. 2018 ОНЫ 10 ДУГААР САРЫН 26- НЫ ӨДРИЙН АЙМГИЙН УДИРДАХ АЖИЛТНУУДЫН ШУУРХАЙ
ЗӨВЛӨГӨӨН ДЭЭР ӨГСӨН ҮҮРЭГ ДААЛГАВАР

№	Өгөгдсөн үүрэг даалгаврын товч агуулга	Хугацаа	Хэрэгжүүлэх байгууллага, албан тушаалтан	Биелэлт
2	Аймгийн иргэд угаарын хийн хордлогод өртөх явдал ихсэж байгаа тул холбогдох байгууллагууд орон даяар сэрэмжлүүлэг мэдээ өгч, уг асуудалд дүн шинжилгээ хийж шалтгааныг тогтоон урьдчилан сэргийлэх арга хэмжээ авах	7 хоног	ОБГ-ын дарга, ЭМГ-ын дарга, Өлгий сумын Засаг дарга болон холбогдох бусад байгууллагын дарга нарт	Эрүүл мэндийн газраас “Угаарын хийн хордлогоос сэргийлэх үйл ажиллагааг эрчимжүүлэх тухай” 5 сарын аяны удирдамжийг боловсруулж аймгийн Засаг Даргаар батлуулан хэрэгжүүлж байна. Аймгийн төвийн 1,2,3,12,13,11-р багуудын 163 айл өрхүүдээр явж угаарын хийн хордлогоос сэргийлэх талаар Өрхийн эрүүл мэндийн төвүүдтэй хамтран ажиллаж зөвлөгөө өгч ажиллаж байна. Мөн Цэнгэл, Дэлүүн сумуудад 20 айл өрхүүдээр явж угаарын хийн хордлогоос сэргийлэх талаар зөвлөгөө өгч гарын авлага тараасан.

2. Аймгийн ЗД-ын захирамжаар баталсан ажлын хэсэгт орж хүүхдийн өвчлөл, эндэгдэл ихтэй Цэнгэл, Дэлүүн сумдад зөвлөн туслах ажлаар ажиллаа.
3. Хүүхдийн өвчлөл, эндэгдэл ихтэй Цэнгэл, Дэлүүн сумдын 19 багийн бага эмч нарыг шавилан сургалтанд хамруулах хөтөлбөрийг гаргаж хүргүүлсэн.
4. Нярайн эрт үеийн нэн шаардлагатай тусламжийг үнэлэх баг төрөх тасагт ажиллаж үнэлгээ хийсэн. Цаашид засаж хэрэгжүүлэх ажлын талаар зөвлөмж өгөгдсөн
5. Аймгийн нийгмийн эдийн засгийг хөгжүүлэх үндсэн чиглэлийн 3 дугаар арга хэмжээний 3.1.6, 3.1.8 заалтуудыг үндэслэн Цэнгэл, Дэлүүн сумуудад 75 хүнд сүрьеэгийн үзлэг хийгдсэн.

6. Мөн 195 хүнд бэлгийн замын халдварт өвчний үзлэг шинжилгээ хийгдэж, 10 хүнээс заг хүйтний өвчлөл илэрч эмчилгээнд хамрагдлаа.
7. Нийгмийн эрүүл мэндийн үндэсний хөтөлбөрүүдийн хэрэгжилт, сүрьеэ, БЗДХ, томуу томуу төст өвчний дэгдэлтийн үеийн бэлэн байдалд хяналт үнэлгээ хийсэн.
8. “Хорт хавдраас урьдчилан сэргийлэх”, “Эрт илрүүлгийн ач холбогдол”, “Тархины цус харвалт”- ын чиглэлээр 2 удаа орон нутгийн радиогоор мэдээлэл хүргүүлсэн

7 хоногийн мэдээ

Зарим статистик үзүүлэлтүүд

Нийт төрөлт - 57

Амьд төрөлт - 56

Амьгүй төрөлт- 1

Дутуу төрөлт - 1

Нялхсын эндэгдэл- 0

1-5 хүртэлх насны хүүхдийн эндэгдэл-0

Эхийн ноцтой хүндрэл- 0

Төрөлхийн гажиг- 2

Гэрийн төрөлт- 0

Аймгийн хэмжээнд амбулаторид суурилсан томуугийн харуулдан тандалтын 18 нэгжүүдэд 43 дугаар долоо хоногт нийт 4599 хүн үйлчлүүлсний 146 (3.1%) нь ТТӨ-тэй тохиолдол бүртгэгдсэн байна. Өмнөх 7 хоногтой харьцуулахад 0,9%-иар өссөн үзүүлэлтэй байна.

Амьсгалын замын цочмог хүнд халдварын шалтгаантай эмнэлэгт хэвтэгсэд нийт хэвтэгсэд (127)-ийн дотор 27 буюу 21.2 %-ийг эзэлж, өмнөх долоо хоногтой харьцуулахад 5.3 %-иар өссөн үзүүлэлтэй байна. Уушгины үрэвслийн шалтгаантай нас баралт бүртгэгдээгүй байна.

Аймгийн хэмжээнд түргэн тусламжийн 302 дуудлагын 46 (15.2 %)-ийг ТТӨ-ий шалтгаантай дуудлага эзэлж байна. Өмнөх долоо хоногтой харьцуулахад 5.8%-иар өссөн үзүүлэлтэй байна.

Аймгийн хэмжээнд 2018 оны 43 дугаар 7 хоногт аймгийн Нэгдсэн эмнэлэг, сумын тандалтын нэгжүүд Томуу, томуу төст өвчний тохиолдол 18 удаа ирүүлэхээс 18(100%) удаа ирүүлсэн байна.